


СҮХБААТАР АЙМГИЙН УГСААТНЫ ЗҮЙН МУЗЕЙН 2024 ОНЫ IV-Р УЛИРЛЫН ТАЙЛАН

1. СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

1.1. Зохион байгуулсан үзэсгэлэн

Түүхэн суут хүмүүсийн суу билгийг алдаршуулах, тэдний эрхэмлэн дээдэлж ирсэн үнэт зүйлс, ур чадвар, ухааныг хойч үе, хүүхэд, залууст сургах, эх оронч өв тэгш монгол хүнийг төлөвшүүлэх зорилготой тус аяны хүрээнд Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музей нь Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, бүх цэргийн жанжин Д.Сүхбаатартай холбогдол бүхий үзмэр, эд өлгийн зүйлсээр “Түүх мартахгүй-2” үзэсгэлэнг дэглэсэн. Түүх мартахгүй-2 үзэсгэлэнд 74 дэсийн 74 ширхэг үзмэр дэглэсэн. Тус үзэсгэлэнг 11 дүгээр сарын 01-ны өдөр нээж 11 дүгээр сарын 31-ны өдрийг хүртэл дэглэгдэж 4 дүгээр 7 хоногийн байдлаар нийт 755 үзэгч үзсэн байна.




1.2. Музейн сан хөмрөгийн баяжилт болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил

Арга зүйн зөвлөлийн хурлаар 46 дэсийн 46 ширхэг эд өлгийн зүйлийг бүртгэн баримтжуулан сан хөмрөгт баяжилт хийхээр шийдвэрлэж, эдгээр эд өлгийн зүйлст эрдэм шинжилгээний тодорхойлолт бичиж, музейн үзмэр эд өлгийн зүйлсийг бүртгэн баримтжуулах заавар маягтын дагуу бүртгэн баримтжуулалт хийж, холбогдох журмын дагуу үнэлгээ тогтоож ажилласан.

Музейн батлагдсан тайлбарыг боловсруулан батлуулж, Тайлбарлагч боловсролын ажилтанг арга зүйгээр ханган ажиллав.

Мөн “Дарьгангын хөргүүд” каталогийг 500 ширхэг, “Дарьганга нэрний учир”, “Үзэмчин нэрний учир” зурагт буддаг ном тус бүр 500 ширхэгийг хэвлүүлэн худалдан борлуулж байна.



1.3. Музейн боловсролын ажил

Сүхбаатар аймгаас гаралтай улс төр, нийгмийн зүтгэлтэн Д.Сүхбаатар жанжины түүх намтар, хийж бүтээсэн үйл хэргийг ирээдүй хойч үеийн хүүхэд, багачуудад таниулан сурталчлах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой “Түүхэн хүмүүнээс суралцахуй” боловсролын хөтөлбөрийг Ерөнхий боловсролын насны хүүхдүүд болон Сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдүүдэд зохион байгуулж 453-н хүүхэд хамрагдсан байна.





Соёл, Урлаг, Аялал жуулчлал, Залуучуудын газар, Угсаатны зүйн музейгээс "Бид Сүхбаатарын хүүхдүүд" ярилцлага, музейн боловсролын хөтөлбөрт арга хэмжээг ерөнхий боловсролын 2-р бүрэн дунд сургуультай хамтран зохион байгууллаа. Арга хэмжээнд Баруун Урт сумын ЕБС-иуд оролцон "Миний мэдэх Д.Сүхбаатар" илтгэлийг Д.Сүхбаатарын нэрэмжит 1-р сургуулийн 10г ангийн сурагч М.Марал, У.Үүрийнтуяа /багш М.Ганбаатар/, 2-р сургуулийн 10С-1 ангийн сурагч Ш.Ариунаа

/багш Б.Мөнхбат/, 3-р сургуулийн 10а ангийн сурагч М.Дөлгөөнтамир /багш Г.Гэрэлцэцэг/, 4-р сургуулийн сурагч Дэлгэрцэцэг /багш Б.Дэлгэрмаа/ нар тавьлаа. Оролцогчдын дунд "Түүхэн хүмүүнээс суралцахуй" музейн боловсролын хөтөлбөрийг зохион байгуулж тус арга хэмжээнд нийт 136 хүн хамрагдсан.



Соёлын бүтээлч сарын 4 дүгээр 7 хоногийн байдлаар музейн зохион байгуулж буй үйл ажиллагааг сурталчлан [\(5\) Facebook](#) цахим хуудсаар 25-н төрлийн мэдээ, мэдээллийг бэлтгэн хүргэж нийт 3675 хүнд мэдээллийг түгээн ажилласан байна.



2.АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ БОЛОН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

2.1. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах

Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музей нь Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2024-2027 он бодлогын баримт бичгийн Музейн захирлын 2024оны 05 сарын 02-ны өдрийн А/28 тоот тушаалаар үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. 2024 онд 4 зорилтын хүрээнд 9-н арга хэмжээг төлөвлөн ажилласан. Уг хөтөлбөр хэрэгжсэнээр Албан хаагчдын цалин, хөлс урамшууллын системийг өрсөлдөх чадвартай болгосон. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлээр улирал бүр үндсэн цалингийн 40 хүртлэх хувийн үр дүнгийн нэмэгдэл, мөн улирал тутам Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Соёлын сайд, Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалын хавсралт "Соёл, Урлагийн салбарын төрийн



үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийг тус тус үндэслэн ур чадварын урамшуулал олгон ажиллаж байна. Тайлант онд нийт 16 албан хаагчдад 26789000 төгрөгийн үр дүнгийн урамшуулал, 10 албан хаагчдад 27736831 төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгосон байна. Мөн байгууллагын шилдэг ажилтанд 1,000,000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгон ажилласан.

Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн судалгааг 7-н агуулгын хүрээнд 27-н асуулга бүхий сэтгэл ханамжийн судалгааг 15-н албан хаагч хамрагдсан. Албан хаагчдаас авсан ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг нэгтгэн удирдлагад танилцуулсан. Ажлын байрны сэтгэл ханамжтай байдал 70,5 хувьтай байна. Нээлттэй асуултад Бичиг хэргийн тоног төхөөрөмж муу, Барилга байгууламж ажиллахад хүйтэн, Өвлийн улиралд ажлын байр хүйтэн, Өрөө тасалгааны засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж муу, Үзвэрийн танхимд агааржуулалтын систем байхгүй гэсэн асуудлууд бичсэн байна. Албан хаагчдын ажлын байрны ажиллах хэвийн нөхцөлийг хангах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажилласан. 1. Албан хаагчдын өрөө тасалгаанд тогтмол цэвэрлэгээ үйлчилгээ хийж хэвшсэн. 2. Боловсролын танхимд 3,479,000 төгрөг зарцуулан засвар үйлчилгээ хийснээр тайлбарлагч боловсролын ажилтны ажиллах нөхцөл болон боловсролын танхимаар үйлчлүүлэгчдийн орчин нөхцөл сайжирсан. 3. Түр үзэсгэлэнгийн танхимд 816,900 төгрөг зарцуулан засвар хийсэн. 4. Ариун цэврийн өрөөнд засвар хийж хүүхдийн суултуур шинээр байрлуулсан нийт 1,203,100 төгрөг зарцуулсан. 5. Албан хаагчдад шаардлагатай тоног төхөөрөмжийг яамны санхүүжилт болон байгууллагын санхүүжилтээр авсан. Яамны санхүүжилтээр зөөврийн компьютер, зургийн аппарат, принтер 7247250 төгрөг, батлагдсан төсвийн хүрээнд /суурин компьютер, зөөврийн компьютер, скайнер, өнгөт принтер, лазер принтер, ухаалаг дэлгэц, танхимд кондейшн, усны апарат, цахилгаан халаагуур гэх мэт нийт 28201900 төгрөгийн, нийт 40948150 төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хийсэн байна.



2.2. Сургалт

1.Орон нутгийн өмчийн газраас зохион байгуулсан Хөрөнгийн удирдлага сэдэвт сургалтад байгууллагын өмч хамгаалал зөвлөл болон Нягтлан бодогч, Нярав хамрагдсан.



2.Соёл, урлагийн салбар байгууллагуудын албан хаагчдыг чадавхижуулах сургалтад 10-н албан хаагч хамрагдав.





3. Соёлын яамнаас зохион байгуулсан “Бүртгэл мэдээллийн санч болон хүний нөөцийн ажилтан нарт” зориулсан цахим сургалт болон Угийн бичиг хөтлөх арга зүй сургалтад албан хаагчид хамрагдсан.

4. Удирдлагын академийн монгол бичгийн цахим сургалтын анхан шатны 40 цагийн хичээлийг 9-н албан хаагч, Ёс зүйн сургалтад 2 албан хаагч хамрагдан гэрчилгээ авсан.



5. Монгол бичгийн 30 цагийн сургалтыг 4-р сургуулийн багшаар 300,000 төгрөгөөр албан хаагчдад ажлын байранд заалгасан. Мөн музейн захирал удирдах албан тушаалтнуудын дунд зохион байгуулсан сургалтад хамрагдан талархал авсан.



3.СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНААС ЗОХИОН БАЙГУУЛСАН ХЯНАЛТ ШАЛТГАЛТ

Соёлын яамны төлөвлөгөөт шалгалтын бэлтгэл ажлыг ханган ажилласан. 2024 оны 11 сарын 08-ны өдөр соёлын улсын байцаагч тус байгууллага дээр ирж хяналт шалгалтыг хийж ажилласан. Хяналт шалгалтын дүнгийн хурлыг хийж танилцуулахад дунд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн.



4.АЛБАН БИЧИГ

- Ирсэн бичиг - 28
- Явсан бичиг - 15
 - Хариутай бичиг – 6
 - Хугацаандаа явсан бичиг – 6
 - Хугацаа болоогүй бичиг – 1
 - Хугацаа хэтэрсэн бичиг – 0

5.ТАЙЛАН, МЭДЭЭ

- Сар бүрийн 25-ны дотор СУАЖЗ-н газарт гарын үйл ажиллагааны мэдээг хүргүүлэн ажиллаж хэвшсэн.
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 9-н зорилтийн 39-н арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнан СУАЖЗГ, ХШҮ-ний хэлтэст албан тоотын хамт хүргүүлсэн. Мөн Төрийн мэдээллийн сүлжээ цахим системд оруулж баталгаажуулсан.
- ХШҮ-ний хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 10 хууль тогтоомжийн 13-н заалтын хэрэгжилтийг төрийн мэдээллийн сүлжээ цахим системд тайлагнан баталгаажуулсан.
- Албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах тайлангийн хурлыг зохион байгуулж, үнэлгээний баг үнэлсэн.

6.ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ

Соёлын бүтээлч сарын хаалтын үйл ажиллагаа “СОЁЛ, СПОРТ-ЭВ НЭГДЭЛ” уулзалтад байгууллагын 8-н албан хаагч оролцсон. Спорт өдөрлөгт 2 албан хаагч оролцож багаараа алтан медал хүртэв. Мөн аймгийн төвийн соёлын 4-н байгууллагын дунд зохион байгуулсан караоке тэмцээнд 2-р байр эзлэв.



Орчин цагийн музей үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын хурал Улаанбаатар хот төрийн ордонд 12 дугаар сарын 24-ны өдөр зохион байгуулагдаж 5-н албан хаагч 2 ахмад болон 1 цуглуулагчийн хамт оролцсон.

ДҮГНЭЛТ

Үзэсгэлэн, Соёлын өвийн боловсрол олгох хөтөлбөр, Цахим орчинд музейн үзмэрийг сурталчлах, Хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзмэр болон өвлөн уламжлагчийг сурталчлан таниулах, Үндэсний бичиг, соёлын жил -2024, эх хэлний өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулж Соёлын өвийн боловсрол олгох хөтөлбөр-8, Цахим орчинд музейн үзмэрийг сурталчлах 30-н үзмэр, Хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзмэр болон өвлөн уламжлагчийг сурталчлан таниулах-4 нэвтрүүлэг, 1 баримтат кино, Үндэсний бичиг, соёлын жил-2024, эх хэлний өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх-1 үзэсгэлэн, сэдэвт үзэсгэлэн-6 дэглэн иргэдэд хүргэсэн. Үзэсгэлэнг нийт-5510 үзэгч, Соёлын өвийн боловсрол олгох хөтөлбөрт 2030 иргэн, Цахим орчинд музейн үзмэрийг сурталчлах арга хэмжээ-23000 хүнд хүрсэн байна.

Музейн тасалбарыг нэг удаа музей үзэх 5000 төгрөгийн тасалбар, гэр бүлээрээ /2 насанд хүрэгч/ музей үзэх тасалбар, музей үзэх гэрэл зураг авах, Дарьганга дээл өмсөж зураг даруулах, байгууллагын бүртгэл мэдээллийн сангаас лавлагаа авах гэсэн 5-н төрлөөр төрөлжүүлэн иргэдэд үйлчилж байна. Нийт 605 иргэнд бэлэн бус тооцооны хэрэгсэл буюу пос машин ашиглан төлбөр хураамжийг авч 3,025,000 төгрөгийн тасалбар борлуулан ажилласан. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орон нутгийн соёлын салбарын эдийн засгийн үр нөлөөг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд үзмэрийн зурагт тайлбар бүхий Нандин өв мөнгөн урлалын каталоги болон ил захидлуудыг борлуулж 2,030,000 төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан байна. Мөн “Дарьгангын хөргүүд” каталогийг 500 ширхэг, “Дарьганга нэрний учир”, “Үзэмчин нэрний учир” зурагт буддаг ном тус бүр 500 ширхэгийг хэвлүүлэн худалдан борлуулж байна.

ТАЙЛАН БИЧСЭН: АРГА ЗҮЙЧ

(Ж.НАРАНЧИМЭГ)

ХЯНАСАН: ЗАХИРАЛ

(Д.АРИУНДЭЛГЭР)

